



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2009 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах
тухай

Тус газрын "Дүрэм"-ийн 4.5 заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. ХБНГУ-ын Берлин хотноо 2009 оны 3 дугаар сарын 11-16-ны өдрүүдэд болох ИТВ-2009 үзэсгэлэнд тус газрын гадаадын зах зээл хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Батхүү овогтой Батмөнхийг томилон явуулсугай.


Хоёр. Үзэсгэлэнд оролцох удирдамжийг батлуулан, 2009 оны 3 дугаар сарын 25-ны дотор тайланг танилцуулахыг гадаадын зах зээл хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Батмөнхөд даалгасугай.



ДАРГА

Ш.СҮХБААТАР

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА  Ш.СҮХБААТАР



**“ITB 2009” ОЛОН УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.БАТМӨНХИЙН
АЖЛЫН УДИРДАМЖ**

Зорилго: Улаанбаатар хотын аялал жуулчлалыг олон улсын зах зээлд сурталчлах, аж ахуйн нэгжүүдийг нэгдсэн зохион байгуулалттайгаар гадаад зах зээлд гаргах, сурталчилгаа хийхэд нь дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахад оршино.


Хугацаа: 2009 оны 3-р сарын 11-16-ны өдрүүдэд ХБНГУ-ын БЕРЛИН хотноо болно.

Оролцох байгууллага: БОАЖЯ, Нийслэлийн Аялал Жуулчлалын газар, Монголын Аялал жуулчлалын холбоо, Үндэсний аялал жуулчлалын байгууллага, аж ахуйн нэгжүүд.

Хийх ажил:

1. “ITB 2009” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт Улаанбаатар хотоос оролцогч компаниудыг нэгдсэн удирдлагаар хангаж оролцох,
2. Үзэсгэлэнд оролцож байгаа бусад орны хотуудын аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчидтэй уулзаж хоёр хотын хамтын ажиллагааны талаар санал солилцох,
3. Үзэсгэлэнгийн үеэр буюу 2009 оны 3 дугаар сарын 13-ны өдөр ITB үзэсгэлэнгийн хэвлэлийн танхимд Монголын талаас олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудыг урьж хэвлэлийн бага хурал зохион байгуулах ажилд оролцох. Хэвлэлийн бага хурлын үеэр Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын аялал жуулчлалын хөгжил, төрийн бодлого, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг танилцуулах, мэдээлэл хийх,
4. Тус улсад Монгол улс, түүний нийслэл Улаанбаатар хотын сурталчилгааг хөгжүүлэх арга замыг судлах, холбогдох хүмүүстэй уулзах,
5. Үзэсгэлэнд оролцогчдын дунд санал асуулга явуулж дүн шинжилгээ хийх болон бусад эх сурвалжид үндэслэн үзэсгэлэнгийн үр дүнг тодорхойлон газрын даргад 2009 оны 03 дугаар сарын 24-ний дотор танилцуулж, санхүүгийн холбогдох тооцоог хийж дуусгах.

БОЛОВСРУУЛСАН:
Аялал жуулчлалын газрын
ахлах мэргэжилтэн



Б.Батмөнх